
МОНГОЛ УЛС

болон

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК

хоорондын

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

(Ердийн нөхцөл)

ҮНДСЭН НӨХЦӨЛ

(Банкны салбарыг сэргээх, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх хөтөлбөр)

Огноо:

МОН 51054

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР (Энгийн үйл ажиллагаа)

МОНГОЛ УЛС (цаашид “Зээлдэгч” гэх) болон АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК (цаашид “АХБ” гэх) хооронд оны дугаар сарын-ны өдөр байгуулсан ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР.

ҮҮНД:

(А) АХБ нь Зээлдэгчээс энэхүү хэлэлцээрийн Хавсралт 1-д тодорхойлсон, Зээлдэгчийн нийгмийн халамжийн салбарыг хөгжүүлэх (цаашид “Хөтөлбөр” гэх)-д чиглэсэн зорилго, бодлого хийгээд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дурдсан бодлогын захидал (цаашид “Бодлогын захидал” гэх)-г ... оны ... сарын ...-ны өдөр хүлээн авсан;

(Б) Зээлдэгч нь хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор АХБ-нд зээл авах хүсэлт гаргасан бөгөөд;

(В) АХБ нь тус банкны хөрөнгийн энгийн эх үүсвэрээс Зээлдэгчид дор дурдсан нөхцөлийн дагуу зээл олгохыг зөвшөөрөв.

ИЙМЭЭС, Талууд дараахь асуудлаар хэлэлцэн тохиролцов:

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Зээлийн зохицуулалт, нэр томъёо

Заалт 1.01. АХБ-наас 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр баталсан “Энгийн үйл ажиллагааны зээлийн журам” (цаашид “Зээлийн журам” гэх)-ын бүх заалт дор дурдсан өөрчлөлтийн хамт энэхүү зээлийн хэлэлцээрт бүрнээ тусгагдсаны нэгэн адил хүчин төгөлдөр мөрдөгдөнө. Үүнд:

(а) Заалт 2.01(tt)-ийг хэрэгсэхгүй болж дараах заалтаар орлуулсан

“Хөтөлбөр” гэж АХБ-аас Зээлийн хэлэлцээрт тусгагдсаны дагуу зээл олгохыг зөвшөөрсөн, АХБ болон Зээлдэгч харилцан зөвшилцсөний дагуу тодорхойлолт нь тухай бүр өөрчлөгдөж болох хөтөлбөрийг хэлнэ.

(б) “Төсөл” хэмээх нэр томъёог зээлийн журамд дурдагдах бүрт нь “хөтөлбөр” хэмээн ойлгоно,

(в) Заалт 2.01(vv)-ийг хэрэгсэхгүй болж дараах заалтаар орлуулсан.

“ХХБ” буюу “Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллага” гэж Зээлийн хэлэлцээрт заасан нөхцөл дор хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүргийг хүлээх тал(ууд)-ыг хэлнэ,

(г) “Төсөл хэрэгжүүлэгч байгууллага” хэмээх нэр томъёог зээлийн журамд дурдагдах бүрт нь “хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллага” хэмээн ойлгоно,,

Заалт 1.02 Энд тохируулга хийсэн болон нөхцөл байдал өөрөөр шаардсанаас бусад бүх тохиолдолд Зээлийн журам дахь нэр томъёонуудыг тэнд өгүүлснээр ойлгоно. Хэлэлцээрт шинээр хэрэглэгдсэн зарим нэр томъёог дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- (а) “Монголбанк” гэж Зээлдэгчийн төв банк буюу Монголбанкыг хэлнэ.
- (б) “Засгийн газрын хариуцах хөрөнгө” гэж хөтөлбөр хэрэгжүүлэх явцад зээл ашигласнаас буй болох зээлийн хэлэлцээрийн Хавсралт 4-ийн 4-р догол мөрд заасан төгрөгөөрх мөнгөн дүнг хэлнэ,
- (в) “Хадгаламжийн данс” гэж Хавсралт 3-ын 3-р догол мөрд заасан дансыг хэлнэ,
- (г) “ХДК” гэж Хадгаламжийн даатгалын корпораци эсхүл түүнийг залгамжлах аливаа байгууллагыг хэлнэ.
- (д) “Зөвшөөрөгдөх зүйлс” гэж зээлийн хэлэлцээрийн Хавсралт 3-ын 1-р хэсэгт заасан импортыг хэлнэ,
- (е) “СЗХ” гэж Зээлдэгчийн санхүүгийн зохицуулах байгууллагыг хэлнэ.
- (ё) Зээлийн зарцуулалтын гарын авлага” гэж АХБ-ны 2015 онд батлагдаж тухай бүр шинэчлэгдэж байсан Зээлийн зарцуулалтын гарын авлагыг хэлнэ,
- (ж) “СЯ” гэж Монгол Улсын Сангийн яам буюу түүнийг залгамжлах аливаа байгууллагыг хэлнэ,
- (з) “Бодлогын матриц” гэж Хөтөлбөрийн хүрээнд Зээлдэгчийн хэрэгжүүлсэн болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон бөгөөд Зээлдэгч, АХБ-ын харилцан тохирсон, Бодлогын захидлыг дагалдах матрицыг хэлнэ.
- (к) “Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллага” хэмээх нэр томъёог Зээлийн журамд заасан зорилго, агуулгынх нь хүрээнд Сангийн яам буюу түүнийг залгамжлах, хөтөлбөр хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн АХБ-ны хүлээн зөвшөөрсөн байгууллагыг хэлнэ,
- (л) “Төрийн банк” гэж Зээлдэгчийн газар нутаг дээр үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит банкыг хэлнэ.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Зээл

Заалт. 2.01. (а) АХБ нь Зээлдэгчид тус банкны хөрөнгийн энгийн эх үүсвэрээс нэг зуун сая (100,000,000) ам.доллартай тэнцэх хөрөнгийг зээлүүлэхийг

зөвшөөрөв. Зээлийн хөрөнгийг энэхүү зээлийн хэлэлцээрийн 2.06 заалтын дагуу тухай бүр өөр валютад хөрвүүлж болно.

(б) Зээлийн үндсэн төлбөрийг эргүүлэн төлөх хугацаа 12 жил бөгөөд үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа нь энэ хэсгийн (в)-д тодорхойлсон хугацаатай байна.

(в) Энэ хэсгийн (б)-д заасан "Үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа" гэж энэхүү зээлийн хэлэлцээрийн Хавсралт 2-т заасны дагуу үндсэн зээлийг эргүүлэн төлж эхлэх анхны товлосон хугацаа хүртэлх үеийг хэлнэ.

Заалт. 2.02. Зээлдэгч нь авч ашигласан, эргэн төлөгдөөгүй үндсэн зээлийн үлдэгдэлд АХБ-нд хүү төлнө. Хүү төлөх хугацаа бүрт хүүгийн хувь нь:

(а) LIBOR; болон

(б) Зээлийн журмын 3.02-т заасны дагуу тооцоолсон 0.60%-иас уг журмын 3.03-т заасан 0.10%-ийн кредит (зээлжих эрх)-ийг хассан дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

Заалт 2.03. Зээлдэгч жилд 0.15%-ийн хөрөнгө байршуулсны төлбөр төлнө. Төлбөрийг энэхүү зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болсоноос хойш 60 хоногийн дараагаас эхлэн зээлийн нийт хэмжээ (зээлээс зарцуулах тухай бүр уг дүн багасна)-н дээр тооцно.

Заалт 2.04. Хүү болон зээлийн бусад шимтгэлийн төлбөрийг хагас жил тутамд жил бүрийн 2 дугаар сарын 15 болон 8 дугаар сарын 15-ны өдөр төлнө.

Заалт 2.05. Зээлдэгч зээлийн данснаас ашигласан зээлийн үндсэн өрийг энэхүү зээлийн хэлэлцээрийн Хавсралт 2-т дурдсан төлбөрийн хуваарийн дагуу эргүүлж төлнө.

Заалт 2.06. (а) Зээлдэгч өрийн оновчтой удирдлагыг хангахын тулд зээлийн нөхцөлийг дараах аль нэг байдлаар өөрчлөх хүсэлтийг хэдийд ч гаргаж болно. Үүнд:

- (i) Авч ашигласан ба эргэн төлөгдөөгүй, эсхүл авч ашиглаагүй зээлийн үндсэн өрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн зээл олгогдсон үндсэн валютаас батлагдсан валют руу шилжүүлэх;
- (ii) Авч ашигласан ба эргэн төлөгдөөгүй зээлийн үндсэн өрд бүхэлд нь, эсхүл аливаа нэг хэсэгт нь үйлчлэх хүүгийн төвшинг өөрчилж, хөвөгч хүүнээс тогтмол хүү рүү, эсхүл эсрэгээр тогтмол хүүнээс хөвөгч хүү рүү шилжүүлэх;
- (iii) Авч ашигласан ба эргэн төлөгдөөгүй зээлийн өрдд бүхэлд нь, эсхүл аливаа нэг хэсэгт нь үйлчлэх хөвөгч хүүнд дээд, доод зааг хэмжээ тогтоох замаар хөвөгч хүүнд хязгаарлалт хийх.

(б) Дээрх (а) заалтын дагуу гаргасан өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг АХБ хүлээн зөвшөөрсөн бол түүнийг зээлийн журмын 2.01(6) заалтад тодорхойлсончлон “Өөрчлөлт” гэж авч үзэх бөгөөд уг өөрчлөлт нь Өөрчлөлт оруулах тухай удирдамж болоод зээлийн журмын 5 дугаар зүйлийн заалтуудын дагуу хүчин төгөлдөр болно.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Зээлийн хөрөнгийг ашиглах

Заалт 3.01. Зээлдэгч нь зээлийн хөрөнгийг энэхүү зээлийн хэлэлцээрийн заалтуудын дагуу хөтөлбөрийн хүрээнд гарах зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна.

Заалт 3.02. Зээлийн хөрөнгийг энэхүү зээлийн хэлэлцээрийн Хавсралт 3-т заасны дагуу хуваарилж, ашиглах бөгөөд Зээлдэгч, АХБ хоёр харилцан тохиролцсоноор уг хавсралтад тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Заалт 3.03. Зээлийн журмын 9.02 заалтын зорилгоор зээлийг хаах өдөр нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр байх ба эсхүл Зээлдэгч, АХБ харилцан тохиролцож шинээр товлосон өдөр байна.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Тусгай нөхцөл

Заалт 4.01. Зээлдэгч нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад энэхүү зээлийн хэлэлцээрийн Хавсралт 4-т заасан бүх үүргийг биелүүлэх буюу биелүүлэх нөхцөлийг хангана.

Заалт 4.02. (а) Зээлийн журмын 7.01 болон 7.04 заалтад заасан мэдээлэл, тайлан гаргах ажлын хүрээнд Зээлдэгч нь хэрэв АХБ-наас хүсэлт гаргасан тохиолдолд (i) Хамтран хэрэгжүүлэгчийн санхүүжилт болон түүний ашиглалт, (ii) Хөтөлбөрийн хэрэгжилт, зорилтуудын биелэлт болон бодлогын захидалд дурдсан арга хэмжээний гүйцэтгэлийн талаар мэдээлэл, тайлан гаргаж өгөх буюу тийнхүү гаргуулах нөхцөлийг хангана.

ТАВДУГААР ЗҮЙЛ

Хүчин төгөлдөр болох

Заалт 5.01. Зээлийн журмын 10.04 заалтын зорилгоор энэхүү зээлийн хэлэлцээр нь түүнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 90 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ

Бусад зүйл

Заалт 6.01. Зээлийн журмын 12.02 заалтын зорилгоор Зээлдэгч талын төлөөлөгчөөр Зээлдэгчийн Сангийн сайдыг томилов.

Заалт 6.02. Зээлийн журмын 12.01 заалтын зорилгоор дараахь албан ёсны хаягийг ашиглана. Үүнд:

Зээлдэгч:

Сангийн сайд
Засгийн газрын II байр
С.Данзангийн гудамж-5/1
Улаанбаатар-15160
Монгол Улс
Факс: 976-11-320247

АХБ:

Азийн хөгжлийн банк
Азийн хөгжлийн банкны өргөн чөлөө 6
Мандалуйонг хот
1550 Метро Манила
Филиппин Улс
Факс: (632) 636-2444
(632) 636-2384.

ҮҮНИЙГ НОТЛОН, талууд зохих ёсоор эрх олгогдсон төлөөлөгчдөөрөө дамжуулан энэхүү зээлийн хэлэлцээрийн эхэнд дурдсан өдөр гарын үсэг зурж, АХБ-ны Төв байранд хүргүүлнэ.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ

ХАВСРАЛТ 1

Хөтөлбөрийн тодорхойлолт

1. Хөтөлбөрийн үндсэн зорилго нь нийгмийн халамжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэх бөгөөд энэ хүрээнд (а) банкны салбарын бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх зураглалыг бүрэн боловсруулах, (б) санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулах, (в) салбарын өрсөлдөөнт орчин, засаглалыг сайжруулах юм.
2. Хөтөлбөрийг 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөж байна.

ХАВСРАЛТ 2

Зээлийг эргүүлэн төлөх хуваарь

1. Дараахь хүснэгтэд үндсэн зээлийн өрийг төлөх огноо болон уг өдөр төлөх үндсэн зээлийн нийт өрийн төлөх хувь (хэсэгчилж төлөх хувь)-ийг тодорхойлов. Үндсэн зээлийн өр төлж эхлэх өдрийн байдлаар зээлийн хөрөнгийг бүрэн авч зарцуулсан тохиолдолд АХБ үндсэн зээлийн өр төлөх өдөр тухай бүр Зээлдэгчийн төлөх үндсэн зээлийн хэмжээг: (а) үндсэн зээлийн өр төлж эхлэх өдрийн байдлаар авч зарцуулсан бөгөөд эргэн төлөгдөөгүй зээлийн үндсэн зээлийн үлдэгдлийн нийт дүнг; (б) үндсэн зээл төлөх өдөр тухай бүрт тодорхойлсон хэсэгчилж төлөх хувиар үржүүлж тооцоолно. Шаардлагатай тохиолдолд энэхүү хуваарийн 4–т заасан валютын өөрчлөлт хийгдсэн дүнг хасч тооцох замаар уг эргүүлэн төлөх дүнг тохируулан өөрчилнө.

Төлбөр хийх хугацаа

Хэсэгчилж төлөх хувь
[(хувиар илэрхийлнэ)]

2. Үндсэн зээл төлж эхлэх өдрийн байдлаар зээлийн хөрөнгийг бүрэн авч зарцуулаагүй тохиолдолд үндсэн зээл төлөх өдөр тухай бүрт Зээлдэгчийн эргэн төлөх үндсэн зээлийн өрийн хэмжээг дараахь байдлаар тодорхойлно. Үүнд:

(а) Үндсэн зээлийн өрийг төлж эхлэх өдрийн байдлаар авч зарцуулсан байвал зохих зээлийн хөрөнгийн хүрээнд Зээлдэгч нь дээр дурдсан өдрийн байдлаар авч зарцуулсан эргэн төлөгдөөгүй зээлийн үлдэгдлийг энэхүү Хуваарийн 1 дэх заалтын дагуу эргүүлэн төлнө.

(б) Үндсэн зээлийн өр төлж эхлэх өдрөөс хойш авч зарцуулсан зээлийг тухайн зарцуулалт хийгдсэн өдрөөс хойш тохиох үндсэн зээлийн өр төлөх өдөр тухай бүр АХБ-ны тодорхойлсон хэмжээгээр эргүүлэн төлнө. АХБ уг эргүүлэн төлөх зээлийн хэмжээг тодорхойлохдоо тухайн авч зарцуулсан зээлийн хөрөнгийн хэмжээ бүрийг бутархай тоогоор үржүүлэх бөгөөд уг бутархайн хүртвэр нь энэхүү хавсралтын 1 дэх заалтын хүснэгтэд тодорхойлсон үндсэн зээлийн өр төлөх тухайн өдрийн хэсэгчилж төлөх хувь (хэсэгчилж төлөх эх хувь), харин бутархайн хуваарь нь үндсэн зээлийн өр төлөх үлдсэн өдрүүдийн хэсэгчилж төлөх эх хувиудын нийлбэр байна. Шаардлагатай тохиолдолд энэхүү хавсралтын 4-т заасан валютын өөрчлөлт хийгдсэн хэсгийг хасч тооцох замаар тухайн эргэн төлөх дүнг тохируулан өөрчилнө.

3. Үндсэн зээлийн өр төлөх аливаа өдөр төлөх үндсэн зээлийн хэмжээг гагцхүү тодорхойлох зорилгоор үндсэн зээлийн өр төлөх аливаа өдрөөс өмнө хуанлийн 2 сарын дотор авч ашигласан зээлийн хөрөнгийг тухайн өдрийн дараагийн үндсэн зээлийн өр төлөх өдрийн байдлаар авч ашигласан боловч эргэн төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл хэмээн тооцох ба түүнийг мөнхүү дараагийн өдрөөс эхлэн буюу түүнээс хойшхи үндсэн зээлийн өр төлөх өдөр бүр эргүүлэн төлнө.

4. Энэхүү хавсралтын 1 болон 2 дахь заалтад зааснаас үл хамааран, авч ашигласан үндсэн зээлийн өрийн валютыг бүхэлд нь болон хэсэгчлэн өөрчилж, зөвшөөрсөн валютад хөрвүүлсэн тохиолдолд АХБ тийнхүү хөрвүүлэх үед тохиож буй

үндсэн зээлийн өр төлөх аливаа өдөр төлөх, зөвшөөрсөн валютад хөрвүүлсэн зээлийн хэмжээг тодорхойлно. Ингэхдээ АХБ хөрвүүлэлт хийхээс өмнөх үндсэн валютаар илэрхийлсэн зээлийн дүнг: (i) энэхүү хөрвүүлэлттэй холбоотой валютын баталгаат /hedge/ гүйлгээний хүрээнд АХБ-наас төлөх, зөвшөөрсөн валютаар илэрхийлсэн үндсэн зээлийн дүнг харуулсан валютын ханшаар үржүүлэх буюу, эсхүл (ii) АХБ өөрчлөлт оруулах тухай удирдамжийн дагуу тогтоосон дэлгэцийн (screen) үнийн валютын ханшаар үржүүлнэ.

5. Авч ашигласан бөгөөд эргэн төлөгдөөгүй үндсэн зээлийн дүнг хэд хэдэн валютаар олгосон тохиолдолд энэхүү хавсралтын заалтууд нь валют тус бүрээр олгосон зээл нэг бүрт тус тусад нь үйлчлэх ба чингэснээр, зээлийг эргэн төлөх хуваарийг валют тус бүрээр боловсруулна.

ХАВСРАЛТ 3

Зээлийн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт

1. Хэрэв АХБ өөрөөр тусгайлан зөвшөөрөөгүй бол зээлийн хөрөнгийг зээлийн данснаас гаргахад энэхүү хавсралтын дор дурдсан заалтыг баримтална.
2. Зээлдэгч нь зээлийн данснаас гүйлгээ хийх хүсэлтийг АХБ-ны шаардлагыг хангахуйц маягтаар үйлдэж, АХБ-нд хүргүүлнэ.
3. (а) Зээлдэгч нь АХБ-нд зээлийн данснаас анхны гүйлгээ хийх хүсэлтийг хүргүүлэхээс өмнө Монголбанкинд данс (Хадгаламжийн данс) нээсэн байх ба зээлийн данснаас гарах бүх гүйлгээ тус данс руу орно. Хадгаламжийн дансыг нээх, ашиглах, хаах үйл ажиллагааг АХБ-ны шаардлагад нийцсэн нөхцөлийн дагуу хийнэ.

(б) Хадгаламжийн данстай холбоотойгоор нэмэлт данс нээх, бүртгэл хөтлөх ажиллагааг АХБ-ны шаардлагад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн зарчмын дагуу явуулна. Зээлдэгч нь АХБ-наас хүсэлт гаргасан тохиолдолд хадгаламжийн дансны санхүүгийн тайланд мэргэжлийн ур чадвар, туршлага, ажлын даалгаврын хувьд АХБ-ны шаардлагыг хангасан хөндлөнгийн аудиторoor олон улсын аудитын стандарт, эсхүл АХБ-нд хүлээн зөвшөөрөгдөхүйц дотоодын аудитын стандартын дагуу хөндлөнгийн аудит хийлгэнэ. Эдгээр аудит хийсэн санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлтийн хуулбарыг бэлэн болсон даруйд нь, эсхүл АХБ-наас тийнхүү шаардлага тавьсанаас хойш 6 сарын дотор англи хэлээр бэлтгэж, АХБ-нд хүргүүлнэ.
4. Энэхүү хавсралтын хавсралт 1-т заасан зүйлсийг зээлийн санхүүжүүлтээр худалдан авч болохгүй болно.
5. Зээлдэгч нь бодлогын матрицад тусгасан 1 дүгээр үе шатны бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж дууссаны дараа 1 дүгээр үе шатын санхүүжилтийг авч болно.
6. Энэхүү зээлийн хэлэлцээрийн аливаа бусад заалтаас үл хамааран, түүнчлэн хэрэв АХБ өөрөөр тусгайлан зөвшөөрөөгүй бол АХБ Зээлдэгчтэй зөвлөлдсөний дараа дараахь нөхцөл биелсэн талаар хангалттай итгэл үнэмшилтэй болоогүй тохиолдолд зээлийн данснаас хоёрдугаар шатны санхүүжилтийн ямарваа гүйлгээ хийхгүй. Үүнд: (а) Зээлдэгч хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хангалттай ахиц гаргасан байх; (б) Зээлдэгч эхний шатны санхүүжилтийн гүйлгээ хийхэд авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээг үргэлжлүүлэн мөрдсөн хэвээр байх; ба (в) энэхүү хавсралтын 2 дугаар хавсралтад заасан санхүүжилтийн гүйлгээг хийхэд шаардагдах бодлогын арга хэмжээг Зээлдэгч хэрэгжүүлсэн байх зэрэг нөхцөл хамаарна.

Сөрөг жагсаалт

Зээлийн хөрөнгийг дараах зориулалтаар ашиглахыг хориглоно.

- (i) НҮБ-ын Худалдааны ангиллын олон улсын стандартын 3 дахь удаагийн нэмэлт өөрчлөлтөөр тодорхойлогдсон дараах бүлэг, дэд бүлэгт болон дараа дараачийн нэмэлт өөрчлөлтөөр тоорхойлогдох бүлэг, дэд бүлэгт хамаарах, АХБ-аас Зээлдэгчид хүргүүлсэн мэдэгдэлд заасан бараа бүтээгдэхүүнтэй хологдох зардал,

Хүснэгт. Хориотой бараа бүтээгдэхүүн

Зүйлийн дугаар	Заалтын дугаар	Барааны талаар
112		Согтууруулах ундаа
121		Тамхи, үйлдвэрийн бус тамхи, тамхины хаягдал
122		Тамхи, үйлдвэрлэгдсэн (тамхи орлуулалч агуулагдсан эсэхээс үл хамаараад)
525		Цацраг идэвхт болон холбогдох бодисууд
667		Сувд, үнэт болон хагас үнэт чулуу- боловсруулсан болон боловсруулаагүй
718	718.7	Цөмийн реакторууд болон тэдгээрийн сэлбэг хэрэгслүүд, түлшний цэнэг болон реакторт ашиглагдаагүй бусад хэрэгслүүд,
728	728.43	Тамхи боловсруулах тоног төхөөрөмж
897	897.3	Алт, мөнгө, платины ангиллын металаар хийгдсэн цаг, цагны гэрээс бусад эдлэлүүд, дарханы хэрэгслэлүүд
971		Алт, эргэлтийн бус (алны хүдэр, баяжмалаас бусад)

Эх сурвалж: Нэгдсэн Үндэстний Байгууллага

- (ii) Зээлдэгч орны мөнгөн тэмдэгтээрх зардлууд болон зээлдэгчийн нутаг дэвсгэрээс нийлүүлэлт нь хийгдсэн бараа бүтээгдэхүүнтэй холбогдох зардал,
- (iii) Дотоодын олон гадаадын анк санхүүгийн байгууллага санхүүжүүлсэн болон санхүүжүүлэхээр зөвшөөрсөн гэрээ, үүний дотор АХБ-ны зээл, буцалтгүй тусламжаар санхүүжигдсэн гэрээний дагуу нийлүүлэгдсэн бараа бүтээгдэхүүний зардал,
- (iv) Мэргэжлийн болон мэргэжлийн бус цэргийн зориулалтын болон тансаг хэрэглээний бараа бүтээгдэхүүний зардал,
- (v) Хар тамхины зардал,
- (vi) Байгаль орчинд хор хөнөөлтэй, Зээлдэгч орны хууль тогтоомжоор болон зээлдэгчийн нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу үйлдвэрлэх, ашиглах, импортлохыг нь хориглосон болон АХБ, Зээлдэгч хоорондын харилцан ойлголцлоор айгаль орчинд сөрөө нөлөөтэй хэмээн тодорхойлсон бараа бүтээгдэхүүний зардал,
- (vii) НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлөөс НҮБ-ын Дүрмийн 7-р зүйлийн дагуу гаргасан шийдвэрийн улмаас төлбөр хийхийг хориглосон аливаа зардал.

ХАВСРАЛТ 4

Хөтөлбөрийн хэрэгжилт ба бусад асуудал

Хэрэгжилтийн зохион байгуулалт

1. Зээлдэгч хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагаар Сангийн яамыг томилох бөгөөд тус яам бодлогын арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх ажлыг зохицуулалтаар хангаж, хяналт тавина. Түүнчлэн Зээлдэгч Монголбанкныг хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагаар томилох ба Монголбанк нь хөтөлбөрийн зарим бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх үүргийг хүлээнэ.

Бодлогын арга хэмжээ ба зөвшилцөл

2. Зээлдэгч нь бодлогын захидал болон бодлогын хүснэгтэд тодорхойлсон, хөтөлбөрийн хүрээнд авч явуулах бүхий л бодлогын арга хэмжээг 2019 оны 12 дугаар сар хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр хэрэгжих нөхцөлийг баталгаажуулна.

3. Зээлдэгч нь бусад хоёр болон олон талт тусламжийн байгууллагатай хийж буй, хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлж болох бодлогын яриа хэлэлцээний талаар АХБ-нд мэдээлэл өгөх бөгөөд тэдгээрээс үүдэн гарах аливаа бодлогын зөвлөмж, төслийн талаар санал зөвлөгөө өгөх боломжийг АХБ-нд олгоно. Зээлдэгч нь аливаа бодлогын зөвлөмж, төслийг эцэслэн шийдвэрлэж, хэрэгжүүлэхийн өмнө АХБ-ны саналыг харгалзан үзнэ.

Хамтран хэрэгжүүлэгчийн хөрөнгийг ашиглах

4. Зээлдэгч нь өөрийн талаас гаргах хөрөнгийг хөтөлбөрийн зорилтуудтай нийцсэн тодорхой хөтөлбөр, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулах асуудлыг хариуцна.

5. Зээлдэгч нь арилжааны банкуудын чанаргүй зээлийг шийдвэрлэх, банкны салбарыг сэргээхэд дэмжлэг болгох зорилгоор дор хаяж дөчин сая (40,000,000 ам.доллар) ам.долларыг гаргахыг баталгаажуулна.

Засаглал ба авлигатай тэмцэх

6. Зээлдэгч болон хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллага нь: (а) АХБ-ны Авлигатай тэмцэх бодлого (1998) (нэмэлт, өөрчлөлтийн хамт)–ыг дагаж мөрдөн, АХБ хөтөлбөртэй холбоотой аливаа авлига, луйвар, хуйвалдаан, эсхүл албадлагын талаарх мэдээллийг шууд, эсхүл өөрийн төлөөлөгчөөрөө дамжуулан шалгах эрхтэйг хүлээн зөвшөөрч, (б) аливаа ийм шалгалтын үед хамтран ажиллаж, шалгалтыг хангалттай түвшинд хийж дуусгахад бүх талын дэмжлэг үзүүлнэ.

Хяналт-шинжилгээ

7. АХБ болон Зээлдэгч нь хөтөлбөрийн хэрэгжилтийг улирал тутам үнэлж, дүгнэнэ. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хянаж, үр нөлөөг нь үнэлэх үүднээс АХБ болон Зээлдэгч нар хөтөлбөрийн үр дүн болоод үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн тохиролцоно.